ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№1

Объектын нэр: Дулааны улиралд ашиглах 6х12 метрийн хэмжээтэй, 2,7 метр өндөр хэмжээтэй сууц, 12 ширхэг

Үндсэн шаардлага:

1. Суурь- М250 маркийн бетон зуурмагаар сууцны суурийг хэв харшмалаар хашиж 20см зузаантай хийнэ. Сууцны хананы ирмэгээр 35^0 налуу хаялгыг бетон зуурмагаар хийнэ
2. Хийц- Төмөр хийцийн ханын зузаан 5 мм-ээс багагүй ГОСТ 19903-74 стандартыг хангасан байна. Ган каркас бүхий төмөр арагт бүтээцтэй, зөөвөрлөх боломжтой хийсэн байна.
3. Хана- 100мм-ийн галд тэсвэртэй MNS 4284:2006 Галын аюулаас хамгаалах стандартыг хангасан солонгос хийцийн ханийн сэндвич хавтан өндөр нь 2,7м өндөртэй байна. Гадна хананы хаалганы баруун дээд хэсэгт 50х40см хэмжээтэй байрны дугаарыг тод өнгөөр бичсэн байна
4. Дээвэр- Бороо, цас шороон шуурганы үйлчлэлд тэсвэртэй дээврийн сайн чанарын сэндвич хавтангаар дээврийг цас бороо тогтоод байхааргүй налуу хийж гүйцэтгэнэ. Гурвалжин дээврийн үзүүр хэсэг нь хананаас 30см илүү гарсан байна.
5. Хаалга- Төмөр самбартай, давхар резинен жийргэвчтэй /тайвшруулагч нугастай/ 2.05х0.96см хэмжээтэй сайн чанарын металь хаалга 1 ширхэг байх. Хаалгыг суурилуулахдаа салхины үйлчлэлийг тооцож онгойх чиглэлийг тодорхойлж суулгана. Хаалганд БНбД 81-55-05 норм дүрмийг мөрдлөг болгон ажиллаж, дотоодод үйлдвэрлэсэн төмөр хаалга байж болно. Хаалганы босгоноос гарж ороход хялбар байхаар шат хийсэн байна.
6. Цонх- Сууц нь 5 ширхэг 150х200см хэмжээтэй 3 давхар шиллэгээтэй 76мм-ийн 3 тасалгаат, 1 жижиг тасалгаа нь онгойдог байхаар хуванцар рамтай MNS төлөвлөх ба өргөж тээвэрлэхэд гэмтэл үүсэхгүйгээр бат бөх байна.
7. Шал- 3мм зузаантай квадрат төмрөөр шалны хөндлөвч хэсгийг гагнаж хучилтыг 3см хатсан банзаар шаллаж Сайн чанарын удаан эдэлгээ, элэгдэлд тэсвэртэй паркетин шаргал өнгийн шалыг хийж, бор шаргал өнгийн хүрээ хийнэ.
8. Цахилгаан- 80вт /led/ 6ш 150лк багагүй чадалтай дотор гэрэлтүүлэг, гадна гэрэлтүүлэг 1 ширхэг, 2 даралттай 1ш унтраалгыг хийж, розетка 2 оролттой 6ш хананд /ил/ суурилуулж, ПРОВОД-КГ 2.5*2 маркийн цахилгааны ил монтаж, хуваарилах самбар, далдлагчаар далдалж гал хамгаалагчийн хайрцгаар тоноглоно.
9. Өнгө- Дээвэр хэсгийг цэнхэр, ханийг саарал өнгөөр хийсэн байна.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№2

Объектын нэр: Угаалтуур, усанд орох хэсэг байгуулах /40тн контейнер тоноглох/

Үндсэн шаардлага:

1. Хийц- 40 тонны багтаамжтай 2,4х12 метрийн хэмжээтэй 6 угаалтуур, 12 дүш байрлуулсан контейнер байна.
2. Хана- Контейнерын голоор нь 2 хувааж ханийг 5х7 прүүс модоор рам зангидан 10см зузаантай хөвөнгөөр дулаалж, осп хавтангаар ханийг хийж давхар хулсан хавтангаар дотор ханийг доторлож эрэгтэй, эмэгтэй гэж 2 хуваан хийнэ.
3. Тааз- 5х7 прүүс модоор рам зангидан хийж 10см зузаантай хөвөнгөөр дулаалж осп хавтангаар ханийг хийж давхар хулсан хавтан таазанд хийнэ.
4. Цахилгаан- Дотор монтажийг ил хийж угаалгын өрөөний таазанд 4ш гэрэл, 2ш разетка (ус чийгийн хамгаалалтын тагтай) хуваарилах самбар ханад байрлуулна. Дүшний өрөөний тасалгаа болгонд чийгээс хамгаалсан гэрэл байрлуулж, бойлуур 5кв хүчин чадалтай суурилуулж 25А автоматыг хайрцагт байрлуулна. Цахилгааны утас ПРОВОД-КГ 2х2,5 зэс голтой орос утсаар хийгдэнэ.
5. Шал- Контейнерын шалыг сайн чанарын хулдаасыг шаланд дэвсэх. (өнгийг захиалагчтай зөвшилцөнө)
6. Хаалга- Сайн чанарын давхар резинен жийргэвчтэй /тайвшруулагч нугастай/ 2,05х0,96 хэмжээтэй 2 ширхэг металь хаалга байна.
7. Цонх- Агаар сэлгэхээр 0,5х0.8 см хэмжээтэй 2 давхар шиллэгээтэй 76мм-ийн 1 тасалгаат хуванцар вакум 4 ширхэг цонхтой /бууралтай хуулгатай байна/. (цонхны онгойлтыг захиалагчтай зөвшилцөнө)
8. Сантехник- Дотор хэсэгт бохир, цэвэр усны холболт хийгдэнэ. Цэвэр усны нөөцийн савыг 1000 литрийн багтаамжтай хуванцар саванд вакум насосыг холбож, дүш болон угаалтуурт 100 литрийн бойлерт холболт хийнэ. Цэвэр усны холбоосыг 20-PVC хоолойгоор хийж, угаалтуур дүшний хэсэгт тус бүр 6ш холигч нь халуун хүйтэн усны оролтой байна. Дүшний тусгаарлах ханийг хулсан хавтангаар хийж цайвар өнгийн хаалт хөшиг хийж саван хэрэгсэл тавих тавиурыг тус бүрд нь хийнэ. /засвар үйлчилгээ хийхэд саадгүй байхаар төлөвлөх/.
9. Бусад- Ган бүтээцийг зэврэлтээс хамгаалж бүдэг цэнхэр өнгөөр будан өргөж, зөөвөрлөх боломжтой байхаар гүйцэтгэнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№3

Объектын нэр: Нийтийн бие засах байгууламж /40тн контейнер тоноглох /

Үндсэн шаардлага:

1. Хийц- 40 тонны багтаамжтай 2,4х12 метрийн хэмжээтэй 6 угаалтуур, 10 суултуур байрлуулсан контейнер байна
2. Хана- Контейнерын голоор нь 2 хувааж ханийг 5х7 прүүс модоор рам зангидан 10см зузаантай хөвөнгөөр дулаалж, осп хавтангаар ханийг хийж давхар хулсан хавтангаар дотор ханийг доторлож эрэгтэй, эмэгтэй гэж 2 хуваан хийнэ.
3. Тааз- 5х7 прүүс модоор рам зангидан хийж 10см зузаантай хөвөнгөөр дулаалж осп хавтангаар ханийг хийж давхар хулсан хавтан таазанд хийнэ.
4. Цахилгаан- Дотор монтажийг ил хийж угаалгын өрөөний таазанд 4ш гэрэл, 2ш разетка (ус чийгийн хамгаалалтын тагтай) хуваарилах самбар ханад байрлуулна. Дүшний өрөөний тасалгаа болгонд чийгээс хамгаалсан гэрэл байрлуулж, бойлуур 5кв хүчин чадалтай суурилуулж 25А автоматыг хайрцагт байрлуулна. Цахилгааны утас ПРОВОД-КГ 2х2,5 зэс голтой орос утсаар хийгдэнэ.
5. Шал- Контейнерын шалыг сайн чанарын хулдаасыг шаланд дэвсэх. (өнгийг захиалагчтай зөвшилцөнө)
6. Хаалга- Сайн чанарын давхар резинен жийргэвчтэй /тайвшруулагч нугастай/ 2,05х0,96 хэмжээтэй 2 ширхэг металь хаалга байна.
7. Цонх- Агаар сэлгэхээр 0,5х0.8 см хэмжээтэй 2 давхар шиллэгээтэй 76мм-ийн 1 тасалгаат хуванцар вакум 4 ширхэг цонхтой /бууралтай хуулгатай байна/. (цонхны онгойлтыг захиалагчтай зөвшилцөнө)
8. Сантехник- Дотор хэсэгт бохир, цэвэр усны холболт хийгдэнэ. Цэвэр усны нөөцийн савыг 1000 литрийн багтаамжтай хуванцар саванд вакум насосыг холбож, суултуур болон угаалтуурт 100 литрийн бойлерт холболт хийнэ. Цэвэр усны холбоосыг 20-PVC хоолойгоор хийж, угаалтуурын хэсэгт тус бүр 6ш холигч нь халуун хүйтэн усны оролтой байна. Тусгаарлах ханийг ДСП хавтангаар хийж ариун цэврийн цаас тавих тавиур, хогийн савыг тус бүрд нь хийнэ. /засвар үйлчилгээ хийхэд саадгүй байхаар төлөвлөх/.
9. 13 ширхэг шээлтүүр гадна суурилуулах бөгөөд бохирт холбогдоно.
10. Бусад- Ган бүтээцийг зэврэлтээс хамгаалж бүдэг цэнхэр өнгөөр будан өргөж, зөөвөрлөх боломжтой байхаар гүйцэтгэнэ.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№4

Объектын нэр: Гүний худаг гаргах

Үндсэн шаардлага:

1. Цооног өрөм- Гүний худгийн цооногийг газрын гадаргаас 100-120м гүнтэй өрөмдлөг хийж цооногийн нүхийг 150тай цэвэр усны PVC хоолойг хийж цооногийн нүхэнд нуралт үүсэхээс хамгаалалт хийнэ.

2. Гүний худгийн насос- Хүчин чадал нь 15кВт-ын 100-120м-ийн гүнээс цагт 3-4тн хүртэл ус татах 41 инчийн урттай насос байна.

3. Холбох хэрэгсэл- Худгийн насосыг цооногийн ёроолд суурилуулж нөөцийн сав хүртэл ф32 хоолойгоор хийж гол нь 1 хаалт, 3 булан хийнэ.

4. Цахилгаан- Цооногийн гүнээс худгийн насосыг ПВ-3 35 маркийн 2 голтой утсаар цахилгаан хуваарилах самбарт холбож нөөцийн савны хажууд асааж, унтраах товчлуур төгсгөлд нь гал хамгаалагч автомат суурилуулна. 40w халаагч кабелийг ф32 хоолойгоо ороож хөлдөхөөс сэргийлж хийнэ.

5. Гадна орчноос тусгаарласан байртай байна.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№5

Объектын нэр: Явган хүний зам талбай /Өнгөт хавтан/

Үндсэн шаардлага:

Нийт 615,5 метр урттай 1,5 метрийн өргөнтэй буюу 925 м.кв явган хүний замыг өнгөт хавтангаар гүйцэтгэх.

- ✓ Өнгөт хавтан /30х30х5см/
- ✓ Явган замын хашлага /50х20х8см/

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№6

Объектын нэр: Гадна гэрэлтүүлэг /18 ширхэг/

Үндсэн шаардлага:

Нийт 5 метрийн өндөртэй, бетон суурьтай, нарны эрчим хүчээр асдаг 18 ширхэг гэрэлтүүлэгч суурьлуулах.

д/д	Барааны нэр	Чадал. голч (Ватт)	Тоо ширхэг	Зураг
1	Гадна гэрэл	200 Ватт	18	
2	Шон /төмөр турба/	5 метр	18	
3	Бетон суурь /газарт 70 см ухаж суурийг булах байдлаар суурилуулна/	70 см	18	